



АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ

Яаж
урьдчилан
сэргийлэх
вэ?

Авлига
гэж юу
вэ?

Соён
гэгээрүүлэх
гэж вэ?

Хэн
хийх вэ?

Ямар
хортой
вэ?





3.1.5. "олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа" гэж олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолборыг;

3.1.6. "авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг;



5 дугаар зүйл.Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

5.1.Энэ хуулийн 3.1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

5.1.1.Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах;

5.1.2.төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;

5.1.3.авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах;

5.1.4.сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх;

5.1.5.албан бус боловсролын байгууллага болон сургуулиас гадуурх сургалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад тайлбарлан таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлэх;

5.1.6.хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.

6 дугаар зүйл.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

6.1.Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

6.1.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан нийтлэг үүрэг;

6.1.2.тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх;

6.1.3.төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;

6.1.4.төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх;

6.1.5.тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах;

6.1.6.төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх;

6.1.7.төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;

6.1.8.авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах;

6.1.9.төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах;

6.1.10.төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;

6.1.11.иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

/Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

6.1.12.бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах;

6.1.13.авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих;

/Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/


6.1.14.энэ хуулийн 2¹ дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Төрийн байгууллагууд юу хийдэг?
- Танай байгууллага юу хийдэг вэ?
- Юу хийгээсэй гэж хүсч байна?


АВЛИГААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХИЙН ТУЛД
ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХИЙН ТҮЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?




Эх сурвалж: “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа 2017” судалгааны тайлан.

АВЛИГЫГ БУУРУУЛАХАД ИРГЭД ӨӨРСДӨӨ ХАРИУЦЛАГАТАЙ БАЙХ ЁСТОЙ



ШИЙДВЭР ГАРГАГЧИД ӨӨРСДӨӨ АВЛИГААС ТӨДИЙЛӨН ХОХИРДОГГҮЙ, ЖИРИЙН ИРГЭД Л АВЛИГААС БОЛЖ ХОХИРЧ БАЙНА




Эх сурвалж: “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа 2017” судалгааны тайлан.

Авлигын НИЙТ Өртөг ?

\$2,000,000,000,000


US\$1.5-аас US\$2 их наяд

АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС 2017 (CPI)



- CPI ОНОО : 38 / 100
- УЛСЫН БАЙР : 103 / 180

СРІ ОНОО ба НЭГ ХҮНД ОНОГДОХ ДНБ



Авлигын төсөөллийн индекс 2016

Rank	Country	Score	Rank	Country	Score	Rank	Country	Score	Rank	Country	Score	Rank	Country	Score
1	New Zealand	89	19	Ireland	73	35	Botswana	60	55	Malaysia	49	72	Serbia	42
1	Denmark	88	20	Japan	72	38	Dominica	59	55	Croatia	49	72	Burkina Faso	42
3	Finland	85	21	Uruguay	71	38	Cape Verde	59	57	Jordan	48	75	Turkey	41
4	Sweden	85	22	Estonia	70	38	Lithuania	59	57	Hungary	48	75	Kuwait	41
5	Switzerland	85	23	France	69	41	Costa Rica	58	57	Romania	48	75	Tunisia	41
6	Norway	85	24	Bahamas	66	41	Brunei	58	60	Cuba	47	75	Bulgaria	41
7	Singapore	84	24	Chile	66	41	Spain	58	60	Italy	47	79	Brazil	40
8	Netherlands	83	24	United Arab Emirat.	66	44	Georgia	57	62	Saudi Arabia	46	79	China	40
9	Canada	82	27	Bhutan	65	44	Latvia	57	62	Sao Tom & Prin.	46	79	India	40
10	Germany	81	28	Israel	64	46	Grenada	56	64	Suriname	45	79	Belarus	40
10	Luxembourg	81	29	Poland	62	47	Cyprus	55	64	Montenegro	45	83	Jamaica	39
10	UK	81	29	Portugal	62	47	Czech Rep.	55	64	Oman	45	83	Albania	39
13	Australia	79	31	Barbados	61	47	Malta	55	64	Senegal	45	83	Bosnia & Herz.	39
14	Iceland	78	31	Taiwan	61	50	Mauritius	54	64	South Africa	45	83	Lesotho	39
15	Hong Kong	77	31	Qatar	61	50	Rwanda	54	69	Greece	44	87	Panama	38
15	Belgium	77	31	Slovenia	61	52	Korea (South)	53	70	Bahrain	43	87	Mongolia	38
17	Austria	75	35	Saint Lucia	60	53	Namibia	52	70	Ghana	43	87	Zambia	38
18	USA	74	35	St Vincent and Gren.	60	54	Slovakia	51	72	Solomon Isl.	42	90	Colombia	37

Сичуанийн газар хөдлөлт: 2008



Голланд:

Авлигын түвшин хамгийн бага байдаг улсуудын нэг.

- Байнгын тайлагнал, ил тод байдал
- Авлигын эрсдэл бүхий цэгт мониторинг хийж, тухайн цэгт ажиллаж буй албан тушаалтанд хатуу хяналт тавих тогтолцоо бүрдсэн
- Албаны ёс зүйгээ зөрчсөн албан тушаалтанд хариуцлагыг заасан эрх үүргийн тогтолцоо бий болгосон
- Төрийн байгууллагад ажиллахыг хориглох, нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээ алдах хариуцлагын тогтолцоотой
- Тодорхой төрийн байгууллагуудад тэр дундаа яамдад өөрийн аюулгүй байдлыг хангах алба ажилладаг. Тухайн алба нь албан тушаалтны санаатай болон санамсаргүй хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэх үүрэгтэй.
- Албан тушаалд томилоход авлигын эрсдэлтэй албан тушаалтнуудын жагсаалт гаргадаг
- Албан тушаалтнуудад авлигын хор хөнөөлийг ойлгуулах сургалтын тогтолцоо бий болгосон
- Албан тушаалтнууд өөрт тохиолдсон авлигын тохиолдлыг бүртгэж хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлдэг.
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал ач холбогдолтой. Авлигын тохиолдлыг ил болгож, тогтмол эрэн сурвалжилдаг.

Герман: Албаны чиг үүргээс гадна нийтийн эрх ашгийн үүднээс өөрийн үүргээ шударга, хэлбэрэлтгүй дагаж мөрдөн үүрэгтэй. Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зохицуулалттай.

Албаны шугамаар олж авсан мэдээллийг хэрхэн ашиглах, бэлэг, туслалцаа авах, мөн албанаас чөлөөлөгдсөний дараа 5 жил тухайн байгууллагадаа өөрийн ажлын талаар мэдэгддэг, ямар нэгэн бизнесийн үйл ажиллагаанд өөрөө болон төлөөллөөр оролцохыг хориглосон гэх мэт.

Канад: Нийтийн ашиг сонирхол болон хувийн ашиг сонирхол зөрчилдсөн тохиолдолд төрийн албан хаагч дагаж мөрдөх Ёс зүйн дүрэм гаргаж мөрдөж эхэлсэн.

Албан хаагч томилогдоод 60 хоногийн дотор хөрөнгө орлогоо мэдүүлэх үүрэгтэй гэх мэт.

АНУ: Албан тушаалтнууды хөрөнгө орлогоо мэдүүлдэг, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох, цалингаас өөр орлого олох, бэлэг, хандив авахыг хориглосон.

1977 оноос хойш АНУ-ын Конгрессийн Сенатын танхимын гишүүн, Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн Ёс зүйн кодекс үйлчилж эхэлсэн. Үүнийг Конгрессийн гишүүд болон аппаратын ажилтнууд дагаж мөрддөг.

БНХАУ:

1978 оны 12 дугаар сараас эхлэн сахилга батад хяналт тавих Хятадын коммунист намын Төв комиссын үйл ажиллагаа.

2007 онд Авлигаас урьдчилан сэргийлэх газар байгуулагдсан.

Төрийн албан хаагч нарыг сэлгэн томилсон. Тодорхой хориглолтууд хийсэн.

БНСУ:

Өмнөд Солонгос нь ил тод байдлын жишээ гэж үздэг. 1999 оноос хэрэгжиж эхэлсэн "OPEN" хөтөлбөр. Иргэний хүсэлтийг албан тушаалтан шийдвэрлэж байгааг хянах онлайн систем нэвтрүүлсэн. 2002.01.01-нээс Авлигатай тэмцэх хууль хэрэгжиж эхэлсэн.

Япон:


Олон төрлийн эрхзүйн актуудад авлигаас урьдчилан сэргийлэх заалтууд орсон байдаг. Бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хориглох, албаны мэдээлэл ашиглахыг хориглох гэх мэт. Хүний нөөцийн бодлого нь

Албан тушаалтнуудын цалин хангамж сайн.

ХУУЛЬ ЗҮЙН
ОРЧИН?



Авлигын эсрэг хууль, ТОГТООМЖ



Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай

- 2011

Шилэн дансны тухай

- 2014

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ

Хоёрдугаар бүлэг

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх нийтлэг үүрэг

- 5 дугаар зүйл. Олон нийтийг соён гэгээрүүлэх
- 6 дугаар зүйл. Авлигаас урьдчилан сэргийлэх
- 7 дугаар зүйл. Хориглох зүйлс
- 8 дугаар зүйл. Авлигын талаар мэдээлэх

Гуравдугаар бүлэг

Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, бүртгэх, хадгалах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл, нийтэд мэдээлэх

Дөрөвдүгээр бүлэг

Авлигатай тэмцэх байгууллага

- Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх, чиг үүрэг, бүтэц, албан хаагчид тавигдах шаардлага, тангараг, дарга, дэд даргыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа, албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд тавих хяналт

Тавдугаар бүлэг

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны баталгаа


Зургаадугаар бүлэг

Хариуцлага


Авлигаас урьдчилан сэргийлэх

- Эрсдлийн үнэлгээ
- Үйл ажиллагааны дүн шинжилгээ
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж төлөвлөх
- Биелэлт үр дүнг тооцох

Шударга байдлын үнэлгээ – 2016





ШБҮ, байгууллагын төрлөөр, оноор




Шударга байдлын үнэлгээний 2016 оны дүнгээс харахад үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын дундаж үнэлгээ 69.7 оноотой гарсан нь өмнөх оныхоос 4.2 пунктээр буурчээ. Ийнхүү буурахад тухайн төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээ 6.5 пунктээр, шинжээчдийн үнэлгээ 5.0 пунктээр, тухайн төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдийн өгсөн үнэлгээ 1.0 пунктээр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

ШБҮ, 2016 онд





Архивын ерөнхий газар





ШБҮ

Он	Оноо	Агентлаг -ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	75.3	16/25	27/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт


Дэд үзүүлэлт	Оноо	Агентлаг -ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	75.3	9/24	15/61
-ДШБҮ	74.0	24/25	57/62
-БОҮ	76.7	6/25	10/62

Гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ)	Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ)	Бодлогод оролцогчдын үнэлгээ (БОУ)
---------------------------------------	---------------------------------------	------------------------------------




- Архивын ерөнхий газар
- ЗГ-ын агентлаг
- Улсын дундаж

ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ




	Гадаад шударга байдал	Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол
АЕГ	84.8	63.1	79.8	83.9	100	80
БТСГ	66.5	55.3	70.8	61.9	80.8	68

САЛБАРЫН АЖИЛТНУУДЫН ҮНЭЛГЭЭ



	Дотоод шударга байдал	Соёлын индекс	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Ажлын байранд дахь шударга байдлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэцмэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл
АЕГ	81.6	72.8	82.8	62.8	90.4	98.5	97.5	92.5	100	64
БТСГ	60.9	55.9	70.5	41.3	65.9	94.8	23.2	68.7	90	52.9

ШИНЖЭЭЧДИЙН ҮНЭЛГЭЭ



	Бодлогод оролцогчдын үнэлгээ	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигыг бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
АЕГ	68.5	70.9	49	100	54
БТСГ	56.9	56.6	45	84.4	47.4

СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

Төрийн
байгууллагууд
шударга байдлын
үнэлгээгээ
нэмэгдүүлэхийн
тулд:


- ил тод байдал, хариуцлагатай байдал;
- шударга байдлыг хангах, авлигын эсрэг үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд сурталчлах;
- хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх;
- авлигыг хянах дотоод механизмыг хөгжүүлэх;
- шүгэл үлээх механизмыг дэмжих;
- удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.

Авлигын индексийн судалгаа:

Монгол Улсын Авлигын индекс 2013 онд 0.65 болж 2011 оныхоос 0.02 пунктээр өссөн.


Авлигын индексийн гурван удаагийн судалгааны дүнгээр:

- төрийн байгууллага дахь албан тушаалын хууль бус томилгоо,
- төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил,
- ил тод бус байдал,
- хариуцлага тооцох механизм сул зэрэг нь авлига түгээмэл гэж үзэхэд нөлөөлж байна.




Хээл **хахууль** өгөхийг шаардвал
ТА юу хийх вэ?

ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХИЙГ ШААРДВАЛ ТА ЮУ ХИЙХ ВЭ?




Эх сурвалж: “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа 2017” судалгааны тайлан.

НИЙГЭМД ГАЗАР АВСАН ХҮНД СУРТЛЫГ ШИЙДЭХ ЦОРЫН ГАНЦ АРГА ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ



	3 сар 2006	9 сар 2006	3 сар 2007	9 сар 2007	3 сар 2008	9 сар 2008	3 сар 2009	9 сар 2009	11 сар 2009	3 сар 2014	3 сар 2015	3 сар 2016	3 сар 2017
■ Мэдэхгүй/Хариулаагүй	5.3%	9.4%	9.4%	5.7%	13.1%	11.9%	10.1%	11.5%	9.0%	10.5%	6.8%	7.5%	7.8%
■ Санал нийлэхгүй	34.8%	30.8%	29.9%	29.9%	33.3%	29.4%	35.5%	39.7%	31.3%	34.7%	37.9%	36.2%	34.6%
■ Санал нийлнэ	59.9%	59.8%	60.7%	64.4%	53.6%	58.8%	54.4%	48.8%	59.6%	54.8%	55.3%	56.3%	57.6%

ХЭЭЛ ХАХУУЛЬ НЬ ЗАРИМ ҮЕД ШУДАРГА БУС ДҮРЭМ ЖУРМЫГ ТОЙРЧ ГАРАХАД ТУСАЛДАГ




	3 сар 2006	9 сар 2006	3 сар 2007	9 сар 2007	3 сар 2008	9 сар 2008	3 сар 2009	9 сар 2009	11 сар 2009	3 сар 2014	3 сар 2015	3 сар 2016	3 сар 2017
■ Мэдэхгүй/Хариулаагүй	9.9%	15.4%	12.6%	9.7%	16.1%	13.2%	15.3%	14.7%	12.7%	18.5%	15.1%	11.1%	11.3%
■ Нийцдэггүй	23.3%	19.2%	21.4%	23.8%	30.5%	27.0%	29.0%	32.5%	26.3%	27.3%	35.2%	34.4%	31.5%
■ Нийцдэг	66.8%	65.4%	66.0%	66.5%	53.4%	59.8%	55.7%	52.8%	61.0%	54.3%	49.6%	54.5%	57.3%

8.1. Энэ хуулийн
4.1-д заасан
этгээд албан
үүрэг гүйцэтгэх
явцдаа олж
мэдсэн авлигын
талаарх
мэдээллийг
Авлигатай
тэмцэх газарт
нэн даруй
мэдээлэх
үүрэгтэй.



“Амьд хүний гэрч болсноос үхсэн хүний дэр бол”
“Адгийн зарга арав хоног”
“Төрийн төлөө огтоно боож үхнэ”
“Хар хүний өмнөөс шар хүн”
“Ноёнттой заргалдвал толгойгүй, нохойтой арсалдвал хормойгүй”
“Гүндүүгүй сайхан монгол эр хүн”, “Ичимхий даруу монгол бүсгүй”


ӨРХИЙН ТҮВШНИЙ АВЛИГЫН ДАВТАМЖ



Эх сурвалж: “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа 2017” судалгааны тайлан.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ АВЛИГЫН ТАЛААР МЭДҮҮЛЭХ УТАС АЖИЛЛАЖ БАЙГААГ ТА МЭДЭХ ҮҮ?

Тийм Үгүй



Эх сурвалж: “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа 2017” судалгааны тайлан.



BREAK THE CORRUPTION CHAIN



Хандлагаа өөрчилъе
Биеэ засаад гэрээ зас
Гэрээ засаад төрөө зас



PROGRESSIVE
BUILDING SOCIETY



Ёс суртахуун




Үүрэг, хариуцлага

Үлгэр дуурайлал





“Шилэн” байх



Ил тод байдлыг хангах



Эрсдлийг тодорхойлох



Дотоод хяналт



АВЛИГАГҮЙ НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

Дээвэр муутай байшинд дусаал амархан нэвтэрдэг шиг
Тэлэгдэж гэгээрээгүй ухаан бусдын эрхшээлд автах нь хялбар

You can stop
CORRUPTION

Анхаарлаа хандуулсанд баярлалаа!

www.iaac.mn

1800 - 1969